



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 05 дугаар сарын 20 өдөр

Дугаар 51

Хэрлэн сум

LI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 51 дүгээр хуралдаан 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 08:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 84,6 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдвар /COVID-19/-ын тархалтын шар түвшинд шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

2.Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 46 дугаар тушаалыг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

3.Баян-Уул сум дахь улсын чанартай авто замын суурин хяналтын цэгийн талаар хэлэлцэх,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын

орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

цагдаагийн хурандаа Т.Ганзориг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын



гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын

гишүүн Д.Мөнхтуяа,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1.Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалтын шар түвшинд шилжүүлэх тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд үйлдвэр, худалдаа, үйлчилгээний байгууллагуудыг 07:00-22:00 цагийн хооронд үйл ажиллагаа явуулах, гэр бүлийнхнээс бусад аялал зугаалга, бүх төрлийн уралдаан, тэмцээн, нийтийн бүжиг, өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа, цахим тоглоомын газар, хүүхдийн тоглоомын төвийн үйл ажиллагааг хязгаарлах, худалдаа, үйлчилгээний байгууллагууд нь 18 хувиас бага спиртийн агууламжтай согтууруулах ундаа

 /М.Бадамсүрэн  
 /Д.Баттулга

худалдах, түүгээр үйлчлэхийг 10.00-22.00 цагийн хооронд зөвшөөрөх тухай гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга-д:

1.2.Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалтын шар түвшинд шилжсэнтэй холбогдуулан “Иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ын төсөлд Баян-Уул сум дахь улсын чанартай авто замын суурин хяналтын цэгийг 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн байнгын ажиллагаатай шалган нэвтрүүлэх хяналтын цэг болгон үйл ажиллагааг өргөтгөх, долоо хоног бүрийн Лхагва гарагт Чойбалсан хот, Дашбалбар, Баян-Уул сумаас Улаанбаатар хот, мөн хугацаанд Улаанбаатар хотоос дээрх 3 сумд руу хот хоорондын нийтийн тээврийг явуулах, тус нийтийн тээврээр коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтын бүрэн тун авснаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн зорчигчийг тээвэрлэх тухай Онцгой комиссын гишүүдийн саналыг тусгаж тогтоолоор баталгаажуулах,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1.Аймгийн чанартай шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлага зохицуулалтаар хангах ажлын хэсгийг ахлан Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, авто тээврийн төв, Мал эмнэлгийн газар, Баян-Уул, Хөлөнбуйр сумын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллах,

Гаалийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од-д:

2.2.Хэрлэн сумын шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлага зохицуулалтаар хангах ажлын хэсгийг ахлан Гаалийн газар, аймгийн Засаг даргын Тамгын газар, Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллах,

Гурав.Баян-Уул сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга Д.Баттулга-д:

3.1.Баян-Уул сум дахь улсын чанартай авто замын суурин хяналтын цэгийг 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн байнгын ажиллагаатай шалган нэвтрүүлэх хяналтын цэг болгож холбогдох мэргэжлийн байгууллагуудаас хүн хүчийг нэмэгдүүлэн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА

